

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: А.Нанжидмаа
Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	10
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Э.БАТ-ОРШИХ ТАНАА

2023.02.24 № УВА-2023/16/НА-СТА-ТМБ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

6200700611

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,576,459.00</u>	<u>5,422,800.00</u>
33	АВЛАГА	00.00	241,341.00
335	Бусад авлага	00.00	241,341.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	241,341.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,576,459.00	5,181,459.00
354	Хангамжийн материал	5,576,459.00	5,181,459.00
35410	Бичиг хэргийн материал	273,000.00	132,800.00
35420	Аж ахуйн материал	3,861,759.00	4,035,259.00
35470	Бусад хангамжийн материал	1,441,700.00	1,013,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,869,597.29</u>	<u>56,196,175.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,869,597.29	56,196,175.54
392	Биет хөрөнгө	27,669,597.29	56,056,175.54
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,213,888.83	-8,847,222.15
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,216,700.00	65,994,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,039,916.67	-12,795,719.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,314,576.00	8,090,042.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,407,873.21	-6,185,624.60
393	Биет бус хөрөнгө	200,000.00	140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>33,446,056.29</u>	<u>61,618,975.54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>66,693.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	66,693.00
413	Өглөг	00.00	66,693.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	66,693.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>33,446,056.29</u>	<u>61,552,282.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	33,446,056.29	61,552,282.54
512	Хуримтлагдсан үр дүн	23,793,616.29	51,899,842.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	28,106,226.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>33,446,056.29</u>	<u>61,618,975.54</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	184,596,948.00	412,446,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,678,748.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,678,748.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,678,748.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,520,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	158,748.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,918,200.00	412,446,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,418,200.00	412,446,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,418,200.00	412,446,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	186,074,107.45	384,251,467.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,074,107.45	384,251,467.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,528,574.59	292,049,683.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,807,219.00	166,128,280.00
210101	Үндсэн цалин	60,355,531.00	166,128,280.00
210104	Урамшуулал	28,451,688.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,989,720.14	19,938,076.47
210201	Тэтгэврийн даатгал	10,989,720.14	19,938,076.47
2104	Хангамж, бараа материалын зардал	27,590,819.00	30,518,250.00
210401	Бичиг хэрэг	5,446,185.00	3,113,424.00
210402	Тээвэр, шатахуун	15,286,300.00	21,772,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	629,459.00	547,846.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,273,575.00	4,938,740.00
210408	Бараа материал акталсны зардал	955,300.00	146,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,116,419.00	3,744,300.00
210604	Урсгал засвар	6,116,419.00	3,744,300.00
2107	Томилолт, зочны зардал	653,000.00	23,257,015.00
210702	Дотоод албан томилолт	653,000.00	23,257,015.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,055,374.00	1,083,186.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	744,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	182,250.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,124.00	23,936.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	70,000.00	75,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,316,023.45	47,380,576.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,928,020.00	20,286,633.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,289,357.00	17,844,528.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	15,098,646.45	9,249,415.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,545,532.86	92,201,783.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,891,000.00	44,179,941.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	36,040,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,891,000.00	8,139,141.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,654,532.86	48,021,842.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,654,532.86	48,021,842.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,477,159.45	28,195,232.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	226,276.68	69006.56

20

УБС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ҮЙЛСЭР
 2020 ОНЫ 11 ҮЙ
 САНАА ДҮГНЭЛТ

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,262,766.68	89,006.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,262,766.68	89,006.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	184,438,200.00	412,446,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,520,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,520,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,520,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,520,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,918,200.00	412,446,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,418,200.00	412,446,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,418,200.00	412,446,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	184,438,200.00	412,446,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,438,200.00	412,446,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,699,667.14	320,769,916.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,807,214.00	166,387,928.43
210101	Үндсэн цалин	60,404,049.00	114,253,933.43
210102	Нэмэгдэл	00.00	9,064,383.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	746,000.00
210104	Урамшуулал	28,403,165.00	42,323,612.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,985,373.14	19,853,076.04
210201	Тэтгэврийн даатгал	8,159,239.69	13,964,371.08
210202	Тэтгэмжийн даатгал	874,074.21	1,637,533.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	699,256.60	1,310,026.85
210204	Ажилгүйдлийн даатгал	141,826.98	209,608.33
210205	Эрүүл мэндийн даатгал	1,110,975.66	2,731,535.91
2104	Хангамж, бараа материалын зардал	17,152,648.00	24,223,179.00
210401	Бичиг хэрэг	2,593,750.00	1,305,274.00
210402	Тээвэр, шатахуун	11,193,150.00	18,357,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	629,459.00	547,846.00
210404	Ном, хэвлэл	360,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,376,289.00	4,012,879.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,675,300.00	16,585,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,989,600.00	12,900,000.00
210604	Урсгал засвар	6,685,700.00	3,685,800.00
2107	Томилолт, зочны зардал	534,600.00	23,257,015.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,055,374.00	1,273,186.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	744,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	14,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,124.00	23,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,450.00	22,000.00

20
УБС-ДИММАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТ ОРГОН
САНАА ДЭМБЭЛЭГ

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	70,000.00	265,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,489,158.00	69,189,732.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,740,351.00	48,852,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,748,807.00	20,337,462.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,738,532.86	91,676,783.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,084,000.00	43,654,941.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	36,040,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,084,000.00	7,614,141.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,654,532.86	48,021,842.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,654,532.86	48,021,842.53
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Төгрөг/
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	40,943,542.44	00.00	50,595,982.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	40,943,542.44	00.00	50,595,982.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,149,926.15	00.00	-17,149,926.15
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	23,793,616.29	00.00	33,446,056.29
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	23,793,616.29	00.00	33,446,056.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	23,793,616.29	00.00	33,446,056.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,106,226.25	00.00	28,106,226.25
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,434,260.00	218,180.00	51,899,842.54	00.00	61,552,282.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412,446,700.00	364,424,857.47	48,021,842.53	88.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,446,700.00	364,424,857.47	48,021,842.53	88.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,005,900.00	320,769,916.47	43,235,983.53	88.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,875,700.00	166,387,928.43	8,487,771.57	95.1%
210101	Үндсэн цалин	64,444,200.00	114,253,933.43	(49,809,733.43)	177.3%
210102	Нэмэгдэл	6,547,000.00	9,064,383.00	(2,517,383.00)	138.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,173,300.00	746,000.00	427,300.00	63.6%
210104	Урамшуулал	102,711,200.00	42,928,612.00	60,387,588.00	41.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,859,400.00	19,853,076.04	2,006,323.96	90.8%


210201	Тэтгэврийн даатгал	14,864,400.00	13,964,371.08	900,028.92	93.9%
210202	Тэтгэмжийн даатгал	1,748,800.00	1,637,533.87	111,266.13	93.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,399,000.00	1,310,026.85	88,973.15	93.6%
210204	Ажилгүйдлийн даатгал	349,800.00	209,608.33	140,191.67	59.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,497,400.00	2,731,535.91	765,864.09	78.1%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,662,300.00	24,223,179.00	4,439,121.00	84.5%
210401	Бичиг хэрэг	2,766,000.00	1,305,274.00	1,460,726.00	47.2%
210402	Тээвэр, шатахуун	18,380,300.00	18,357,180.00	23,120.00	99.9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,740,000.00	547,846.00	1,192,154.00	31.5%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,776,000.00	4,012,879.00	1,763,121.00	69.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,627,400.00	16,585,800.00	2,041,600.00	89.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,939,100.00	12,900,000.00	39,100.00	99.7%
210602	Тавилга	2,000,000.00	-	2,000,000.00	0.0%
210604	Урсгал засвар	3,688,300.00	3,685,800.00	2,500.00	99.9%
2107	Томилолт, зочны зардал	32,273,000.00	23,257,015.00	9,015,985.00	72.1%
210702	Дотоод албан томилолт	32,273,000.00	23,257,015.00	9,015,985.00	72.1%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,202,200.00	1,273,186.00	2,929,014.00	30.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,881,900.00	744,000.00	2,137,900.00	25.8%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	144,000.00	-	
210803	Даатгалын үйлчилгээ	532,200.00	74,250.00	457,950.00	14.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,100.00	23,936.00	141,164.00	14.5%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00	50.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	435,000.00	265,000.00	170,000.00	60.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,505,900.00	69,189,732.00	14,316,168.00	82.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,880,900.00	48,852,270.00	13,028,630.00	78.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,625,000.00	20,337,462.00	1,287,538.00	94.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,440,800.00	43,654,941.00	4,785,859.00	90.1%
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,440,800.00	43,654,941.00	4,785,859.00	90.1%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,040,800.00	36,040,800.00	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,400,000.00	7,614,141.00	4,785,859.00	61.4%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	412,446,700.00	412,446,700.00	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	412,446,700.00	412,446,700.00	-	-
132001	Орон нутгийн төсвөөс	412,446,700.00	412,446,700.00	-	
	Байгууллагын тоо	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5.00	5.00	-	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00	-	
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин



Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫНТАСАР

Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,172.9 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		
Авлага	-	241.30	241.3
Бараа материал	5,576.4	5,151.4	(425.0)
Үндсэн хөрөнгө	27,869.5	56,196.1	28,326.6
Нийт хөрөнгө	33,446.0	61,618.9	28,172.9
Өр төлбөр	0.00	66.7	66.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	33,446.0	61,552.2	28,106.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	33,446.0	61,618.9	28,172.9

Авлага дансны үлдэгдэл 241.3 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ыг илүү шилжүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,151.4 мянган төгрөг болж 425.0 мянган төгрөгөөр буурсан нь урьд оны үлдэгдэл хангамжийн материал зарцуулж, бараа материалыг акталснаас шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 56,196.1 мянган төгрөг болж 28,326.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр 37,665.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэж, 3,111.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр данс нь 66.7 мянган төгрөгөөр өссөн нь үйлдвэрчний эвлэлийн татварын зардлыг дутуу шилжүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 61,552.2 мянган төгрөг болж 28,106.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.


3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 276,837.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 152,413.2 мянган төгрөгөөр бууруулж үндсэн үйл ажиллагааны зардлыг 115,424.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор 161,860.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 412,446.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн



хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 412,446.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 412,446.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 82,974.0 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.5 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	192,293.4	168,125.9	24,167.5	87.4%
2	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 80112-нийтлэг үйлчилгээ	11218.5	10952.8	265.7	97.6%
3	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	2,100.0	600.0	1,500.0	28.6%
4	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	48,440.8	43,654.9	4,785.9	90.1%
5	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 80825-БИНХ-ын даргын урамшуулал	33,893.1	31,274.2	2,618.9	92.3%
6	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 82201-ГХУСЗ	46,380.9	33,483.5	12,897.4	72.2%
7	70105-ОНӨУЁ-ны байгууллага, 83201-Ангилдаагүй бусад зориулалт	78,120.0	76,333.4	1,786.6	97.7%
	Нийт дүн	412,446.7	364,424.7	48,021.8	88.4%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 10,494.1 мянга, хангамж бараа материалын зардал 4,439.1 мянга, томилолт зочны зардал 9,015.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2,929.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 14,316.2 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 4,785.8 мянга, эд хогшил худалдан авах зардлаас 2,041.6 мянган төгрөгийг тус тус хэмнэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.


3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 186,074.1 төгрөгөөс 1 хувиар буюу 1,860.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 412,446.7 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,124.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,299.5 мянган төгрөгөөр тогтоолоо

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалт “Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг

гаргахгүй байх гэж тус тус заасныг зөрчин 1,700,000 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

